

Айдас үгүй, зусар үгүй СЭТГҮҮЛ ЗҮЙ

Аравдугаар сарын 18 – 20-ны өдөр | Дэлхийн форум | Гааг хот | Нидерланд

Үзэл баримтлалын баримт бичиг

1. Танилцуулга.

Хараат бус хэвлэл мэдээллийн учир холбогдол

ЮНЕСКО нь 2020 оны тавдугаар сарын 3-нд Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр (ДХЭЧӨ)-ийн 27 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан чиглүүлэх гэж байна. ЮНЕСКО, Нидерландын Вант Улстай хамтран Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний асуудлаарх бага хурлыг дөрөвдүгээр сарын 22-24-ний өдрүүдэд олон улсын энх тайван, шударга ёсны төлөөх үйлсээрээ нэрд гарсан Гааг хотын Дэлхийн Форумын байранд зохион байгуулахаар төлөвлөж байв. Гэвч КОВИД-19-ийн тархалтын улмаас тус бага хурлыг мөн байранд аравдугаар сарын 18-20-ний өдрүүдэд товллоо. Ийнхүү Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг арваннэгдүгээр сарын 2-ны өдөр тохиодог Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох Олон улсын өдөртэй хамтатган тэмдэглэх юм.

Энэ жил хараат бус сэтгүүл зүйг хамгаалан бэхжүүлэхэд гол анхаарал төвлөрч байна. Ингэхийг оролцогч тал бүрт, түүн дотроо засгийн газрууд, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, шүүх засаглал, эрх зүйн салбарынхан, интернэт бизнес эрхлэгчид, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид болон залууст уриалж байна. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр мэргэжлийн сэтгүүл зүй, түүний үндэс болсон хараат бус мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгслийг чанаржуулахад гаргасан амжилтыг мөн цохон тэмдэглэнэ.

Хараат бус байдал нь чөлөөт, хараат бус, олон үргальч хэвлэл мэдээллийн хөгжлийн төлөөнөө 1991 онд батлагдаж, хожим нь 1993 онд НҮБ-ыг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг зарлан тунхаглах сэдэл өгсөн Виндхуккийн Тунхаглалын амин сүнс юм. Уг Тунхаглалд зааснаар, хэвлэлийн эрх чөлөөг хангахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах хүчтэй хууль тогтоомжоос гадна хэвлэл мэдээллийн олон үргальч үзэл, редакцийн хараат бус байдлыг хангахуйц орчин шаардлагатай байна.

Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах зайлшгүй нөхцөл болсон хараат бус байдлыг ийнхүү хангах шаардлагатайг онцлон тэмдэглэх нь өдгөө цагаа олсон хэрэг билээ. Учир нь хэвлэл мэдээллийг хянах арга улам нарийсан, эрчимжиж буй нь олон нийтэд үнэн зөв мэдээлэл, хамтын оролцоот санаа бодол болон соёлын илэрхийллийн олон төрлийг хүргэх сэтгүүл зүйн үүрэгт заналхийлж байна.¹ Гэсэн хэдий ч, редакцийн хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж буй хараа хяналтаас сэтгүүл зүйг чөлөөлөх замаар бодит байдлыг Виндхуккийн туйлын зорилгод дөхүүлэх чиглэлээр хөдөлгөөн идэвхжиж байна. Ингэх нь хүн төрөлхтөн Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-д хүрэхэд амин чухал. ТХЗ нь энх тайван, шударга ёс,

1 Recognition of the importance of editorial independence and diversity of the media is integrated into UNESCO's Media Development Indicators and the Internet Universality Indicators, as well as monitored in the frame of the Organisation's reports on *World Trends in Freedom of Expression and Media Development and Re-Shaping Cultural Policies*.

хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан бөгөөд үүнд хэвлэлийн эрх чөлөө чухал үүрэгтэй.

Хараат бус мэргэжлийн сэтгүүл зүй, хараат бус шүүх засаглалын хамтаар төрийн эрх мэдлийг хувийн эрх ашгийн төлөө эрхшээлдээ оруулахаас сэргийлэхэд онцгой ач холбогдолтой. Эдгээр салбарыг дэмжин хамгаалсан нөхцөлд эрх баригчид болон үүрэг хүлээгчдийн хүний эрхийг хамгаалах, тогтвортой хөгжлийг урагшлуулахын төлөөх эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд тустай.

ДХЭЧӨ 2020-ын үндсэн санаатай НҮБ-ын 75 жилийн ой давхцаж байна. Энэхүү ойг тохиолдуулан, Гишүүн орнуудын зүгээс энх тайван, хүний эрхийн түгээмэл хэм хэмжээг баримтлахад нэн шаардлагатай олон талт байдлыг дэмжихээ илэрхийлээд байна.² Ингэх нь ДХЭЧӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэхэд Гишүүн орнуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх боломж бүрдүүлэхийн зэрэгцээ олон талт эвсэл холбоодыг хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангахад амин чухал хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалахад түлхэц үзүүлнэ.

2. ДХЭЧӨ 2020-ын үндсэн санааг товчоор

Эдүгээ сэтгүүлчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад хийх, ингэхдээ мэдээллийн үрсгалд нөлөөлөх зорилгоор хэвлэл мэдээллийг эрхшээлдээ оруулах, заналхийлэхийг завдагчдын зүгээс сэтгүүл зүйд төрөл бүрийн дарамт учруулсаар байна. Мөн түүнчлэн, өнөөгийн мэдээлэл харилцааны технологийн хувьсгал болоод томоохон интернэт компаниудын өсөлт хөгжил хараат бус сэтгүүл зүйг бас нэгэн сорилттой тулгаруулж, цаашилбал, хэвлэлийн эрх чөлөөний нийгмийн үнэ цэнийг бууруулж байна. Эдгээр өөрчлөлтийн улмаас сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг урьдийнхаас илүү үнэ цэнэтэй, өвөрмөц болж байгаа учраас дэлхий даяар хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн хараат бус байдлыг дэмжих үйл хэрэг эрчимжсээр байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд улс төр, эдийн засгийн хараа хяналт тавьж, мэдээг эрхшээлдээ авдаг байсан түүхтэй. Ингэхдээ, хэвлэл мэдээллийг төрийн эзэмшилд аваад зогсохгүй үүнийгээ хэвлэл мэдээллийн магнатууд, хэвлэл мэдээллийн монополичлол, зар сурталчилгааны нөлөөлөл, олон нийтийн харилцааны төөрөгдүүлэлт зэрэг аргаар гүйцэлдүүлдэг байв. Сүүлийн үед зар сурталчилгаанаас хамааралтай мэдээллийн хэрэгслийн бизнес интернэт компаниудад байр сууриа алдаж буйн улмаас удаан үргэлжилж буй эдгээр сорилт эрчимжиж байна. Үүний зэрэгцээ, хэвлэл мэдээлэл дэх эр жендэрийн давамгайл байдал нь редакцийн халдашгүй бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл болж байна.

²<http://research.un.org/>

Сэтгүүл зүйн хараат бус байдлын талаар анхаарвал зохих асуудал өдгөө хүрээгээ тэлсээр байна. Үүнд, томоохон интернэт компаниуд сэтгүүл зүйн, соёлын контентын гол харгалзагч болж, тэдний нэг хэсэг нь олон нийтийг хуурч төөрөгдүүлэх зорилгоор санаатайгаар түгээсэн худал мэдээлэл, үзэн ядах үг хэллэг зэргийг өөгшүүлсэн бизнесийг сэтгүүл зүйн нэр хүндэд хохирол учруулан эрхэлж байна.

Дайралтын бай болсон мэдээллийн хэрэгслүүд, хувь сурвалжлагчдын эсрэг өш хонзонд түрхирах, нэн ялангуяа эмэгтэй сэтгүүлчид, уран бүтээлчдийг халдлагад өртүүлдэг цахим сувгуудаар дамжуулан өдөөн хатгах явдал тэргүүлж байна.

Энэ бүгд хувийн эрх мэдэл бүхий ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөхөд хүргэдэг. Эдгээр хүчин зүйлс сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээг доройтуулж, хувь хүмүүсийн авч байгаа мэдээлэл болон соёлын контентын мөн чанарыг гажуудуулдаг. Ингэснээр “олон нийтийн мэдээлэлтэй байх эрх, үндсэн эрх чөлөөгөө эдлэх” нийгмийн хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн Тогтвортой хөгжлийн 16.10 дахь зорилтын амин сүнснээс хол ухрах үр дагавартай.

Үүний зэрэгцээ дэлхий даяар хэвлэл мэдээллийн хараат бус байдлын өмнө тулгарах уламжлалт болон шинэ тутам сорилтыг даван туулах үр дүнтэй стратеги боловсруулж байна. ДХЭЧӨ 2020 нь илчлэн таниулах, тэмдэглэн өнгөрүүлэх, эдгээр шалгуураас суралцах боломж юм.

3. Редакцийн хараат бус байдалд хэвлэл мэдээллийг тал бүрээр олзлох сорилт тулгарах нь

Баримт мэдээг нягтлах, нийтийн эрх ашигт нийцүүлэн ёс зүйтэйгээр хэвлэн нийтлэхийг уриалсан сэтгүүл зүйн үндсэн хэм хэмжээг доройтуулан, гажуудуулагч этгээдүүдийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн байгуулах, олзлох эсвэл овжиноор ашиглах тохиолдолд редакцийн хараат бус байдал алдагддаг.³ Шинжээчдийн тодорхойлсноор, эл үзэгдлийг “хэвлэл мэдээллийг олзлох” хэмээдэг. Хэвлэлийн эрх чөлөө нь явцуу эрх ашгаас үүдэлтэй биеэ даасан байдлын тухай ойлголт юм. Үүний зэрэгцээ хараат бус байдлын утга санааны ард мэргэжлийн чанд хэм хэмжээ дагалдана.⁴ Үүнийг зоосны хоёр тал гэж ойлгож болно.

³ Alina Mungiu-Pippidi, cited in

<https://cmds.ceu.edu/sites/cmds.ceu.hu/files/attachment/article/1174/cima-media-capture-book-f.pdf>, p. 2

⁴ This point links to the kind of capture has been described as “cognitive capture”, which results from overly-close association between reporters and the groups in power whom they cover. Stiglitz, J. E. 2017. Toward a taxonomy of media capture https://www8.gsb.columbia.edu/faculty/jstiglitz/sites/jstiglitz/files/Capture2_Taxonomy-of-Media-Capture.pdf

Эрх мэдлийг урвуулан ашиглах явдлыг илчлэх, эрх мэдэлтнүүдээс хариуцлага нэхэх хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйн чадавхи нь бусдад олзлогдох гол бай болдог нь тодорхой.⁵ Хэвлэл мэдээллийг эрхшээлдээ оруулдаг этгээдийн тоонд улс төрийн хүчин, хувийн бизнес болон бусад оролцогч талууд багтдаг. Эдгээр этгээд нь хэвлэл мэдээллийн яриа хэлэлцээнд эрх мэдлээ далайлгах, сэтгүүл зүйн ёс зүй, хэм хэмжээг гүйвуулах замаар улс төр, шашин, үзэл санаа, санхүүгийн зорилгоо гүйцэлдүүлэхийг оролддог. Тэд мэдээ мэдээллийг эрх мэдэлтнүүдээс хариуцлага нэхэхээс зайлуулах нийтлэг санаархалтай байдаг.⁶

Сүүлийн үед нэрд гарсан хүмүүсийн зүгээс сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, мэргэжлийн мэдээ сурвалжлагад үл итгэх байдлыг газар авахуулах зорилгоор өш санасан үйлдэл, яриа өрнүүлэх нь ихэссээр байна. НҮБ дотроо хэд хэдэн тогтоолоор ийм үг ярианаас үүдэх үр дагаврын талаар анхааруулан сануулж, Сэтгүүлчдийн аюулгүй байдал болон ял шийтгэлгүй үлдэх асуудлын талаарх НҮБ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөг дэмжихийг чухалчилж байв.

Дараагийн бүлгүүдэд, олзлох, халдах явдал нь редакцийн халдашгүй бүрэн бүтэн байдал, хараат бус байдалд хэрхэн нөлөөлдөг, хараат бус сэтгүүл зүй дэх интернэт компаниудын үүрэг оролцоо, тэгш байдлыг хангахад жендэрийн хуваарилалт хийх талаар дэлгэрэнгүй өгүүлнэ. Ингэхдээ, эдгээр сорилтод хариу барих олон оролцогч тал болон стратегид анхаарал хандуулав.

4. Улс төр, бизнесийн ашиг сонирхолоор мэдээний чанарыг доройтуулах нь

Засгийн газрууд болон сөрөг хүчний улс төрчдийн зүгээс мэдээллийн хэрэгсэлд улс төрийн хяналт тогтоох нь хэвлэл мэдээллийг олзлох аргын түгээмэл хэлбэр юм. Төр засгийн хараа хяналт нь хэвлэл мэдээллийн нийтийн эзэмшлийн фондыг завших, шилэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд давуу байдал олгон, бусад мэдээллийн хэрэгслийг шийтгэх зорилгоор зар сурталчилгааны төсвийг урвуулан ашиглахад хүргэх нь элбэг. Улс төрийн эрхшээл тогтоох бас нэгэн арга бол харилцаа холбооны зохицуулах байгууллага болон түсгай зөвшөөрөл олгох явцын хараат бус байдалд нөлөөлөх явдал юм. Хувийн мэдээллийн хэрэгсэл сул дорой байхын хэрээр сэтгүүл зүйн хараат бус байдалд харшлах ашиг сонирхол бүхий этгээдүүд олзлох нь хялбар байдаг.

⁵ Schiffrin, A. 2017. In the service of power: media capture and the threat to democracy. Washington, DC and New York: Center for International Media Assistance and Columbia University School of International and Public Affairs. <https://www.cima.ned.org/resource/service-power-media-capture-threat-democracy/>

⁶ A partial bibliography on media capture is available from the Forum Media and Development, and can be found at <https://fome.info/events/symposium-2018/literature>

Эзэмшлийн төвлөрөл, хувийн эзэмшлийн харилцаа холбооны салбар дахь хязгааргүй дамнан эзэмших явдал нь редакцийн хараат бус байдлыг доройтуулсаар байна. Мөн улс төрийн сэдэл бүхий нууц хувь эзэмшигчид хэвлэл мэдээлэлд шургалж байна.⁷ Европын Комисс, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Америк хоорондын Тусгай илтгэгч зэрэг янз бүрийн байгууллагууд тухайн бүс нутаг дахь хэвлэл мэдээллийн олон ургальч үзлийн талаар асуудал дэвшүүлж буй бөгөөд олон оролцогч талын зүгээс өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэхийг шахан шаардсаар байна.⁸ Эзэмшлийн ил тод байдал, зар сурталчилгааны төсвийг урвуулан ашиглахаас сэргийлэх зохицуулалтын асуудлаар бусад байгууллагууд ажиллаж байна.⁹ Төрийн эзэмшил бүхий мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг хангахад институцийн хүчтэй хамгаалалт шаардлагатай. Шийдэлд хүрэхийн тулд мөн харилцаа холбооны зохицуулагчдыг гадны ашиг сонирхлоос хараат бус байхыг шаарддаг. Соёл, урлагийн салбарын хувьд, олон нийтийн бодлого, зохицуулалтаар ардчиллыг цэцэглэн хөгжүүлэхэд чухал хувь нэмэр бүхий чөлөөт, олон төрөлт соёлын илэрхийллийн үүсэл, халдашгүй бүрэн бүтэн байдлыг нь хамгаалан дэмжих боломжтой. Мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх өөрийн зохицуулалт бий болгох нь редакцийн хэм хэмжээг сахихад өөрсдөө эгэх хариуцлагаа тогтооход нэн чухал. Мөн сэтгүүл зүйн ёс зүйг бэхжүүлэх нь редакцийн халдашгүй бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлөхүйц хувь сэтгүүлчдийг авлигад автахын эсрэг хийж буй бас нэгэн арга хэмжээ юм.¹⁰

Сэтгүүл зүйн платформын шинэ хувилбаруудыг хөгжүүлэх, хэвлэл мэдээлэлд залуусын дуу хоолой, оролцоог хангах, эзэмшил болон бизнесийн шинэлэг загвар нэвтрүүлэх зэргээр ил тод, олон төрөл зүйл, сэтгүүл зүйн халдашгүй бүрэн бүтэн байдлыг ханган бэхжүүлэхэд алхам урагшилна. Нуугдмал санхүүжилт бүхий ашигтай бизнесийг, тухайлбал, зарим нэгэн блогчид, нөлөөтэй хүмүүсийн оролцоотой, илчлэх нь авч хэрэгжүүлэх бас нэгэн хэмжээ болно.

⁷ See the Media Ownership Monitor of Reporters Sans Frontières. <http://www.mom-rsf.org/> The Organised Crime and Corruption Reporting Project has also lifted the lid on shell companies, often registered offshore, used to hide the identity of media owners <https://www.occrp.org/en>

⁸ Nelson, M.M. 2017. What is to be done? Options for combatting the menace of media capture. In Schiffrin, A. (ed). 2017. *In the service of power: Media capture and the threat to democracy*. Center for International Media Assistance: Washington DC.

⁹ See Mendel, T., Garcia Castillejo, A, and Gomez, G. 2017. *Concentration of Media Ownership and Freedom of Expression: Global Standards and Implications for the Americas*. UNESCO Montevideo Office: Montevideo. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000248091>; Becerra, M and Mastrini, G. 2019. *La convergencia de medios, telecomunicaciones e internet en la perspectiva de la competencia: Hacia un enfoque multicompreensivo*. UNESCO Montevideo Office: Montevideo.

¹⁰ See the Ethical Journalism Network <https://ethicaljournalismnetwork.org/> and RSF's Journalism Trust Initiative, <https://rsf.org/en/news/rsf-and-its-partners-unveil-journalism-trust-initiative-combat-disinformation>

Хэвлэл мэдээллийг олзлоход зарим тохиолдолд “хараат бус сэтгүүлчдийг яллах хараат шүүх засаглал” нөлөөлдөг.¹¹ Шүүхийн ажилтнууд хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг үр дүнтэй сахин хамгаалахад тэднийг, мөн түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тууштай хамгаалсан хууль тогтоомж, тогтолцоо үйлчлэх шаардлагатай. Нэлээдгүй олон улсын байгууллага, парламентын зүгээс шүүхийн хараат бус байдлыг хангахуйц эрх зүйн орчин бий болгох чиглэлээр ажилласаар байна. ЮНЕСКО нь бусад байгууллагын хамтаар шүүхийн салбарт хамаатай үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг таниулан сурталчлах чиглэлээр дэлхийн хэмжээнд шүүгчид, прокурорууд болон хуульчидтай хамтран ажиллаж байна. Эдгээр алхамыг хэрэгжүүлэх нь нийгмийн үнэт институт болох шүүх засаглал болон хэвлэл мэдээллийг улс төр, бизнесийн эрхшээлд орохоос хязгаарлах учиртай.

Энэ бүх хүчин зүтгэлд ахиц гарч буй төдийгүй хуваалцах урам зоригийн түүхүүд ч байна.

Эргэцүүлэн тунгаах нь

- 1. Хэвлэл мэдээллийн салбарт редакцийн хараат бус байдал, зохицуулагч байгууллагуудын халдашгүй бүрэн бүтэн байдал, төр засгийн сурталчилгааны шударга хуваарилалт зэргийг хамгаалах, сэргээхийн тулд хууль эрх зүйн болон бодлогын ямар хандлага баримтлах вэ?*
- 2. Хэвлэл мэдээллийн төвлөрөл болон эзэмшлийн ил тод бус байдалтай үр дүнтэй тэмцэх, хэвлэл мэдээллийн эзэмшлийн олон янз байдлыг хангах шинэлэг хандлага юу байна?*
- 3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сахин хамгаалах, мөн аливаа эрхшээлд орохоос өөрийгөө хамгаалах хараат бус шүүх засаглалын үнэ цэнийг харуулах ямар жишээ байна вэ?*
- 4. Хараат бус байдал, редакцийн халдашгүй бүрэн бүтэн байдлын төлөөх эгэх хариуцлагын нэг хэсэг болсон өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхийн тулд сэтгүүлчид, иргэний нийгэм болон бусад оролцогчид ямар арга хэмжээ авч байна вэ?*
- 5. Хэвлэл мэдээлэлд халдах, түүнийг олзлох явдал урлагаар дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж байна вэ?*

¹¹ Stiglitz, Joseph, E. 2017. Toward a taxonomy of media capture
https://www8.gsb.columbia.edu/faculty/jstiglitz/sites/jstiglitz/files/Capture2_Taxonomy-of-Media-Capture.pdf

5. Хэвлэл мэдээллийн хараат бус байдал жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүчин зүйл болох нь

Сэтгүүл зүй нийгэмд олон нийтийн оролцоог хэр ханган үйлчилж буй, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг аль зэрэг урагшлуулж буйд нөлөөлөх бас нэг хүчин зүйл бол хэвлэл мэдээллийн удирдах албан тушаал дахь эрэгтэйчүүдийн давамгайл байдал юм. Гол хэвлэл мэдээллийн байгууллагуудын дээд түвшний удирдах албан тушаалд эрэгтэйчүүд 73%-ийг эзэлж буйг саяхан хийсэн судалгаагаар тогтоосон.¹² Хэвлэл мэдээллийн эзэмшлийн хувьд байдал адил төстэй байгаа нь тодорхой.

Тэнцвэрт бус ийм байдал нь эмэгтэй ажилтнууд, жендэрийн дүрслэл болон хэвшмэл ойлголтын талаар хэвлэл мэдээлэл дэх анхаарлын гадна орхигдсон асуудалтай уялдаа холбоотой. Цаашилбал, олон газар эмэгтэй сэтгүүлчид, уран бүтээлчид онлайн сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, үзэн ядах сексист үг хэллэг, троллингд өртөж байдгийг саяхны судалгаагаар олж тогтоосон байдаг.¹³ Иймэрхүү хүндрэл бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг өсөн нэмэгдэж байгаа хэдий ч мэдээллийн олон байгууллагууд асуудлыг шийдэхдээ хойрго хандаж байна. Түүнчлэн, ихэнх нийгэмд урлагаар дамжуулах илэрхийлэлд тавигдах хязгаарлалт, цензурээр, нэн ялангуяа эмэгтэй уран бүтээлчид, эмэгтэй үзэгч, сонсогчдыг ялгаварлан гадуурхаж байна. Ингэх нь эмэгтэйчүүдийн урам зоригийг мохоон, эрхийг нь хязгаарлаад зогсохгүй өөрийн цензурт хүргэж болзошгүй.

Жендэрийн хяналт нь арьс өнгө, угсаа гарал, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхах явдалтай давхардах нь элбэг байдаг. Залуучууд бас үүнд өртөж байна. Хараат бус сэтгүүл зүй нь эдгээр тэгш бус байдлыг арилгахад анхаарлаа хандуулах аваас тогтвортой хөгжлийн чиглэл болсон оролцоог хангах, үл ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад хувь нэмрээ оруулна.

Өнгөрсөн жилүүдэд, нөлөө бүхий хөдөлгөөнүүд оршин буй байдлыг өөрчлөхийг амжилттай уриалан дуудаж, эзэмшил, ажлын байр, сэтгүүл зүйн бүтээлийн контент дэх жендэрийн төлөөллийг тэнцвэржүүлэхэд хүчин чармайлт гаргаж байна.

¹² French, L; Vega Montiel, A; Padovani, C (eds). 2019. *Gender, media & ICTs: new approaches for research, education & training*. Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000368963.locale=en> ; Vega Montiel, A. and Macharia, S. (eds). 2019. *Setting the gender agenda for communication policy: new proposals from the Global Alliance on Media and Gender*; Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000368962.locale=en> ; <https://www.iwfm.org/wp-content/uploads/2018/06/IWMF-Global-Report.pdf>

¹³ <https://www.iwfm.org/wp-content/uploads/2018/09/Attacks-and-Harassment.pdf>; <https://www.ifj.org/media-centre/news/detail/category/press-releases/article/ifj-survey-two-thirds-of-women-journalists-suffered-gender-based-online-attacks.html>

Эргэцүүлэн тунгаах нь

1. *Хэвлэл мэдээллийн эзэмшил болоод удирдах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй ямар амжилттай түүх байна вэ?*
2. *Жендэрийн хэвшмэл үзлийг арилгах, контент дэх олон янз байдлыг үлэмж тусгах зэрэг нийгэмд жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд хэвлэл мэдээлэл, соёлын хэрэгслүүдэд контентын хувьд хийгдсэн нүдэнд харагдах алхам юу байна?*
3. *Сэтгүүлчид, нэн ялангуяа эмэгтэй сэтгүүлчид, чөлөөт сэтгүүлчид, уран бүтээлчдийг дарамт сүрдүүлэг, халдлагаас хамгаалахад тусламж үзүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс ямар сургамж авч болох вэ?*

6. Хараат бус сэтгүүл зүй болон онлайн хэвлэл мэдээллийг дэмжин хамгаалах нь

Интернэт компаниудын зүгээс сэтгүүл зүйн хувилбар, түүн дотроо залуусаар удирдуулсан шинэлэг санаануудад орон зай олгодог билээ. Ингэх нь, ялангуяа хэвлэл мэдээлэл бусдад олзлогдсон нөхцөлд нэн чухал төдийгүй, үүгээрээ илүү олон ургальч, оролцоог хангасан мэдээллийн орчинг хангадаг. Үүний зэрэгцээ, интернэтийн технологи дэлхийн интернэтийн компаниудад хэт төвлөрч байна. Өдгөө эдгээр компаниуд технологи дээр тулгуурласан харилцаа холбоог атгаж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх дэлхийн Тусгай илтгэгчдийн зүгээс хувь этгээд ийнхүү тайлангүй хяналт тогтоох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд эрсдэл учруулж болзошгүйг анхааруулж байв.¹⁴

Интернэт бизнесийн ихэнх загвар нь сэтгэл хөдлөлийг өдөөхүйц контентийг түлхүү хүргэх аргаар хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэн, тэдний мэдээллийг олзлоход тулгуурладаг төдийгүй, ингэснээр баримтад тулгуурласан сэтгүүл зүйн бүтээлийн харагдацыг бууруулах сөрөг нөлөөтэй. Цаашилбал, үзэл бодолд нөлөөлөх сонирхол бүхий этгээдүүд ихэнх онлайн сувгийг бичил зорилтот контентээр дамжуулан, бусдад мэдэгдэхгүйгээр ашигладаг. Энэ бүгд ил тод олон нийтийн талбарын гадна өрнөж, мэдээллийн хэрэгслийн нийгэм дэх хувь нэмрийн үнэ цэнэд ихээхэн харшилж байна.

Үүний үр дүнд, интернэт компаниуд харилцаа холбооны орчинд мэдээллийн хэрэгслүүдийн үүргийг ихээр орлох болсон. Гэсэн хэдий ч, олон нийтийн шахалт шаардлагаар тэдний зүгээс олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, өөрийн зохицуулалтын үр дүнтэй тогтолцоонд нийцэхүйц ёс зүйн код баримтлах хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулж эхлээд байна. Нэлээдгүй оролцогч талуудын зүгээс интернэт компаниудад

14 “Joint Declaration on Challenges to Freedom of Expression in the Next Decade” <https://www.osce.org/representative-on-freedom-of-media/425282>

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 2020 үзэл баримтлалын баримт бичиг

зориулсан хараат бус, олон талт нийгмийн сүлжээний зөвлөл байгуулахыг дэмжиж байна. Цөөнгүй асуулт үлдэж байгаа хэдий ч харилцан яриа эхэллээ.

Эргэцүүлэн тунгаах нь

- 1. Харилцаа холбоонд ийнхүү том байр суурь эзлэх интернэт оролцогчдод зориулсан ямар зохицуулалтыг авч хэлэлцэж байна вэ?*
- 2. Интернэт компаниудын зүгээс хараат бус сэтгүүл зүйн харагдацыг сайжруулах, соёлын илэрхийллийн бүтээлч, олон төрөл байдлыг хангах үүднээс мэдээллийн хэрэгслүүдтэй үр дүнтэй хамтран ажиллаж буй ямар жишээ байна вэ? Үүнийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ?*
- 3. Интернэт компаниудын эгэх хариуцлага, өөрийн зохицуулалтыг сайжруулсаны үр дүнд хуурамч мэдээлэл, үзэн ядах үг хэллэг тараах, сэтгүүл зүйн эсрэг дайсагнахыг завдагчид тэдний платформыг олзлохоос хэр хамгаалах вэ?*
- 4. Хараат бус сэтгүүл зүйн тогтвортой байдлыг ирээдүйд зах зээлийн уналтаас сэргийлэхэд санхүүжилтийн өргөн хүрээний ямар шийдлүүд байна вэ?*

7. Сэтгүүл зүйд эрх чөлөө олгосноор хараат бус байдлыг бэхжүүлэх нь

2020 оны Хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаа нь шийдэлд чиглэсэн хандлагад суурилж, санаагаа чилээсэн хүн бүрийг илүү дорвитой үйлдэлд урамшуулан зоригжуулж, чадавхжуулахад чиглэгдэж байна. Сэтгүүл зүйд учрах дарамт шахалтыг сөрөх, хараат бус байдлыг баталгаажуулах олон янзын хүчин чармайлт өргөжин тэлсээр байна. Шинэлэг аргуудыг тэр тусмаа түгээх нь зохистой бөгөөд төрөл бүрийн оролцогч талуудын хамтын хүчин чармайлт шаардлагатай. ДХЭЧӨ 2020 нь үүнийг хэрэгжүүлэх цаг үе мөн.

Чөлөөт, олон ургальч, хараат бус онлайн оффлайн аль аль хэвлэл мэдээллийн орчин нь хүний суурь эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахад чухал үүрэгтэй. Энэ нь аливаа ардчилсан нийгмийн гол түлгүүр байдаг бөгөөд тогтвортой хөгжлийг хурдасгадаг. Мөн түүнлэн олон олон хүнийг үйлдэлд дайчлах гол үнэт зүйл болдогоороо ач холбогдолтой билээ. Сэтгүүлчид хуулиар хамгаалагдсан, эрэн сурвалжилга хийх, эрх мэдэл бүхий ихэс дээдэс, сонирхогч бүлгүүдийн тодорхой санаа төлөвлөгөөнд уягдахгүйгээр чөлөөтэй, мэргэжлийн түвшинд мэдээлэх, нийтлэх боломж бүрдсэн цагт л тэд ардчиллын болон хөгжлийн боломжоо бүрэн дүүрэн ашиглах тохироо бүрдэнэ. Тэд эрх мэдэлтнүүдээс хариуцлага нэхэх, ил тод байдлыг таниулан сурталчлах, чанартай мэдээллийг түгээх, ёс

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 2020 үзэл баримтлалын баримт бичиг

зүйт, баримтад тулгуурласан харилцаа холбооны экосистем бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой болно.

Хараат бус сэтгүүл зүйг хамгаалахыг зорьсон хүчин чармайлтад чиглэгдсэн 2020 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр сонгуульд оруулах хэвлэл мэдээллийн хувь нэмрийг бэхжүүлж, хуурамч мэдээлэлтэй тэмцэх эрмэлзэл бүхий 2019 оны үндсэн санаанд тулгуурласан юм. Өрнөж буй асуудал, өөрчлөлтийн төлөөх хүчин чармайлтуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлснээр ирээдүйд сэтгүүл зүйн чөлөөт, хараат бус байдлыг хангахад түлхэц болно.

Үүнийг биелүүлэх нь 2020 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн үеэрх болоод цаашдын бодлогын яриа хэлэлцээний хэтийн төлөв билээ.